



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2021/02



ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-13
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	14
Нэг. Эрүүл мэнд.....	15-16
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	17-19
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	20-23
Дөрөв. Гэмт хэрэг.....	24-25
Тав. Мөнгө,зээл	26
Зургаа. Төсөв, санхүү	27-28
Долоо. Үнэ.....	29-32
Найм. Хөдөө аж ахуй	33-34
Ес. Аж үйлдвэр.....	35-39
Арав. Байгаль орчин	40



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 02 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны 02 сард 220 эх амаржиж, 222 хүүхэд шинээр мэндэлж, 63 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 35(13.7%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 34(13.3%)-өөр, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 4(6.0%)-өөр тус тус буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 159 болж 2020 оны мөн үеийнхээс 30(15.9%)-аар буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 3.1, нас баралт 0.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр буурч, нас баралт өмнөх оны мөн үеэс адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 02 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар буурчээ.



1.2 Эрүүл мэнд

2021 оны эхний 02 сарын байдлаар 2.3 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 36.1 хувиар, 65.6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар тус тус буурч, 2.1 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өсчээ.


2021 оны эхний 02 сард 310 эх жирэмсний хяналтанд орсны 90.6 хувь буюу 281 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр буурсан байна.



Түргэн тусламжийн дуудлага 2.9 мянган удаа гарсны 0.5 мянга буюу 17.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 37.5 хувиар, нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 38.3 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 372 хүн бэртэж, 6 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 58(13.5%)-аар, нас барсан хүний тоо 7(53.8%)-оор тус тус буурсан.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 02 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 30.2 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 27.0 хувь, бусад төрлийн өвчин 14.3 хувь, хоол шингээх эрхтний өвчин 11.1 хувь, осол, гэмтэл, хордлого, гадны шалтгаант үхэл өвчин 9.5 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 7.9 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 60 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 112-оор буюу 65.1 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад заг хүйтэн 51.2 хувиар, цусан суулга 50.0 хувиар, тэмбүү 40.0 хувиар, трихоминиаз 36.8 хувиар, сүрьеэ 33.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 02 сарын эцэст 301 болсны 254 (84.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 47 (15.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 28(8.5%) хүнээр буурч, өмнөх сараас 25 (9.0%) хүнээр өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 156(51.8%) нь бүрэн дунд, 74(24.6%) нь дээд, 30(10.0%) нь тусгай дунд, 16(5.3%) нь техник мэргэжлийн, 15(5.0%) нь бүрэн бус дунд, 4(1.3%) нь боловсролгүй, 3(1.0%) магистр, докторын боловсролтой, 3(1.0%) нь бага боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 02 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны эхний 02 сарын байдлаар бүртгэлтэй байсан 33 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 62 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.




1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 02 сарын байдлаар 7846.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 836.9(11.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 02 сард өмнөх оны мөн үеэс 836.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 840.3(19.0%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 159.8(13.9%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 55.6(11.1%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.




Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 02 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 10034.7 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 476.4(5.0%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 7733.1(77.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1200.4(12.0%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 529.2(5.3%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 401.2(4.0%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 170.8(1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг






Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 02 сард нийгмийн халамжийн сангаас 9246 иргэнд 1223.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 6674(41.9%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 555.6(31.2%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны 2 сард 1298 хүн хамрагдсан нь өмнөх оноос 33(2.6%)-оор өсч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 752.6 сая төгрөг болж 297.4(65.3%) сая төгрөгөөр өсчээ.


Нийгмийн халамжийн тэтгэмж 1058 иргэнд 199.0 сая төгрөг, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 295 иргэнд 146.1 сая төгрөг болон нийгмийн халамжийн сангийн зардлыг 3 иргэнд 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 6592 иргэн хамрагдаж, 122.5 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны эхний 02 сарын байдлаар 79 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 37 хүн гэмтэж, 4 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 28(26.2%)-аар буурсан. Гэмтсэн хүний тоо өмнөх оны мөн үеэс 13(54.2%)-аар нэмэгдэж, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 12(85.7%)-аар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 25(50%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2(40%)-оор тус тус буурч, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 12(80.0%)-аар, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(2 дахин)-ээр, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3(4 дахин)-аар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4(5 дахин)-өөр тус тус нэмэгдсэн байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 31.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 34.2 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 6.3 хувийг олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 5.1 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.8 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 3.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 15.2 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8(80.0%)-аар нэмэгджээ.



Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдад нэмэгдэж, Мандах, Хатанбулаг сумдад өмнө онтой адил, Өргөн, Сайхандулаан сумдад гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 92.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 136.6(59.7%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 46.9(50.9%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 37(46.8%) нь гэр орон сууцандаа, 18(22.8%) нь согтуугаар, 6(7.6%) нь гудамж олон нийтийн газарт, 4(5.1%) бүлэглэн, 6(7.6%) хувийг эмэгтэй хүн оролцон, 15(19.0%) нь шөнийн цагаар /22-06 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 215 хүн саатуулагдаж, 29 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 02 сард






Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 36.6 мянга болж өмнөх оноос 0.6(1.7%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 79.7 мянга болж өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020-2021 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 167.5 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2101.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2352.1 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.7(32.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 7.4 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 15.4(0.2%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 0.3(32.1%) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурчээ.



Чанаргүй зээл сарын эцэст 13.2 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 236.1(8.5%)сая төгрөгөөр өсж, өмнөх оны мөн үеэс 5090.3(62.5%) сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2021.02 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2021.02 сард



2.2 Төсөв, санхүү

2021 оны 02 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 3781.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 62.0 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 28.0 хувиар буурсан байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 93.7 хувийг татварын, 6.3 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 02 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 1397.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 43.5 хувь буюу 1067.7 сая.төг-өөр буурч, төлөвлөгөөнөөс 279.4(25.0%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 02 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.5 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.1 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 1.2 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 1.2 хувь, тээврийн бүлэг 0.2 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 1.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 6.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.9 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 5.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.6 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 5.6 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 7.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 4.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 02 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 - 2021 оны 02 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 02 сард аймгийн хэмжээнд 15302 болж, өмнөх оны мөн үеэс 15222 (191 дахин) толгойгоор илүү байна. Нийт хорогдсон малын 58.8 хувийг ямаа, 33.2 хувийг хонь эзэлж байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах, суманд хамгийн их буюу 1450.0 мянган төгрөг, Алтанширээ, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн, Улаанбадрах сумдад хамгийн их буюу 1000.0 мянган төгрөг, Мандах, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Өргөн суманд хамгийн их буюу 1400.0 мянган төгрөг, Хатанбулаг суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Айраг, Иххэт, Эрдэнэ сумдад хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Алтанширээ, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Айраг, Эрдэнэ сумдад хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Алтанширээ суманд хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 02 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 24595.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 43217.3 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.8 дахин, борлуулалт 86.0 хувиар тус тус өссөн байна.

2021 оны 02 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.8 дахин өсөхөд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 12957.1 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 4628.7 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 10.4 хувийг төрийн, 89.6 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.



Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 10.4 хувь, компани 88.7 хувь, өрхийн аж ахуй 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ус түгээлт 2.7 мян.м3-аар, сувагжуулалт 5.1 мян.м3-аар, савласан цэвэр ус 212.9 мян.литрээр, бялуу 0.9 тонноор, хиам 5.5 тонноор, банш, бууз 0.8 тонноор, гутал 32 ширхгээр, нүүрс 137.4 мян.тонноор, цемент 46.6 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

Температур: 2 дугаар сарын дундаж агаарын температур Дэлгэрэх, Алтанширээ сумдад -10.9 градус, бусад сумдын нутгаар -3.3...-9.9 градус хүйтэн, агаарын хамгийн их температур өдөртөө Дэлгэрэх суманд 6 градус, Иххэт суманд 7 градус, бусад сумдад 11-15 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Нийт нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө -24.0...-32.0 градус, өдөртөө нийт нутгаар 15...25 градус дулаан байв.

Хур тунадас: 2 дугаар сард нийт нутгаар цас орж 1...7 өдөр хур тунадастай байж, 0.0...5.2 мм цас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: **1.** Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ, Айраг, Өргөн, Хатанбулаг, Улаанбадрах сумдад ОЖД-аас ахиу, **2.** Дэлгэрэх, Иххэт сумдад ОЖД-аас бага, **3.** Аланширээ, Сайхандулаан, Мандах, Хөвсгөл сумдад ОЖДундаж орчим цас орсон байна.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Хөвсгөл сумдад 20 метр, Мандах суманд 21 метр, бусад сумдын нутгаар 13-17 метр хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Айраг, Алтанширээ, Иххэт, Өргөн, Хатанбулаг сумдад 1...6, бусад сумдад 9-16 өдөр байлаа.

Цасан бүрхүүлийн байдал: 2 дугаар сарын 28-ны байдлаар Мандах, Айраг, Алтанширээ, Сайхандулаан сумдын нутгаар цасгүй, Замын-Үүд, Өргөн, Хатанбулаг сумдад 10 баллын цасан бүрхэцтэй, 1...2 см зузаантай. Бусад сумдын нутгаар зарим газартаа мөстсөн 1-4 баллын цастай, цасны зузаан 5 см хүрэхгүй байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Нийт нутгаар малын усан хангамж цастай газартаа сайн, цасгүй газартаа дунд зэрэг байна.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2021 2020
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	МЯНГАН ХҮН	69.6	69.8	71.2	71.4	100.3
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	228	217	256	222	86.7
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	57	70	67	63	94.0
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	171	147	189	159	84.1
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	1	2	4	3	75.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	0.0	9.1	15.6	13.5	86.5
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 040	504	329	301	91.5
- Үүнээс эмэгтэй	тоо	522	255	163	149	91.4
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	237	203	69	70	102.3
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	3	1	30	8	26.7
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	3		30	8	26.7
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	1	0	0	
Түр ажлын байр					0	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	99	131	172	417	2.4 ²
- 10000 хүнд ногдох	тоо	14	19	24	58	2.4 ²
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	43	65	55	31	56.4
- 10000 хүнд ногдох ***	тоо	10	15	12	7	56.4
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	10343.8	32344.1	6425.6	24595.2	3.8 ²
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	19247.8	37874.2	23235.1	23217.3	99.9

* - 2018,2019,2020 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2020 II	2021 II	Өсөлт	
		тоо			хувь
1.Амбулаторийн үзлэг	мян.хүн	72.3	65.6	-6.7	90.7
2.Ор хоног	мян.хүн	24.4	16.0	-8.4	65.6
3.Урьдчилсан сэргийлэх тарилга	мян.хүн	1.7	2.1	0.4	123.5
4.Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	3.6	2.3	-1.3	63.9
5.Түргэн тусламжийн дуудлага	мян.хүн	4.7	2.9	-1.8	61.7
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	0.8	0.5	-0.3	62.5
6.Осол гэмтлийн өвчлөл	хүн	430	372	-58	86.5
Үүнээс: нас баралт	хүн	13	6	-7	46.2
7.Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	312	310	-2	99.4
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	288	281	-7	97.6
8.Амаржсан эх	хүн	255	220	-35	86.3
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	1	1	0.0
10. 1 хүртэл насандаа ндсэн хүүхэд	хүн	4	3	-1	75.0

1.2 ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 02 сард

	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насанд аа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	220	0	222	3	1
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	2		2		
Хөвсгөл					
Эрдэнэ					
Сайншанд	166		168	2	1
Замын-үүд	52		52	1	

Эх үүсвэр: Аймгийн эрүүл мэндийн газар



1.3 БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 02 сард

	2020 II	2021 II	Өсөлт	
	Тоо			Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	172	60	-112	34.9
Вирус гепатит	0	0	0	0.0
Сүрьеэ	15	10	-5	66.7
Тэмбүү	20	12	-8	60.0
Заг хүйтэн	41	20	-21	48.8
Трихоминиаз	19	12	-7	63.2
Цусан суулга	6	3	-3	50.0
Бусад	71	3	-68	4.2



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 02 сард

Боловсролын түвшингээр	2018 II	2019 II	2020 II	2021 II	2021 II 2018 II	2021 II 2020 II
	хүний тоо				хувь	
ДҮН	1 040	504	329	301	28.9	91.5
Үүнээс: Эмэгтэй	522	255	163	149	28.5	91.4
Магистр, доктор	4	0	2	3	75.0	0.0
Дээд боловсролтой	237	80	84	74	31.2	88.1
Тусгай дунд	52	31	23	30	57.7	130.4
Техник мэргэжлийн	80	29	30	16	20.0	53.3
Бүрэн дунд	578	292	160	156	27.0	97.5
Бүрэн бус дунд	59	49	24	15	25.4	62.5
Бага	10	13	3	3	30.0	100.0
Боловсролгүй	20	10	3	4	20.0	133.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 02 сард

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2020 II	2021 II	2020 II	2021 II	2020 II	2021 II
ДҮН	329	301	17	33	133	119
Айраг	9	8	0	0	3	2
Алтанширээ	9	6	0	0	3	1
Даланжаргалан	8	5	0	0	2	1
Дэлгэрэх	7	0	0	0	3	0
Иххэт	8	0	1	0	2	0
Мандах	2	6	0	0	1	0
Өргөн	4	3	0	0	3	0
Сайхандулаан	13	2	0	0	2	0
Улаанбадрах	5	3	0	0	5	0
Хатанбулаг	8	9	15	12	10	12
Хөвсгөл	4	0	0	0	1	0
Эрдэнэ	7	10	0	0	6	3
Сайншанд	185	185	1	6	73	60
Замын - Үүд	60	64	0	15	19	40

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, жил бүрийн 02 сард

Салбарын ангилал	2020 I-II	2021 I-II
	Тоо	
Бүгд	52	40
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт		0
Уул уурхай олборлох аж үйлдвэр		0
Боловсруулах үйлдвэрлэл		3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент		1
Барилга	2	0
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ		0
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		0
Мэдээлэл, холбоо		0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа		2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	9
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын	17	0
Боловсрол	8	1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	6	4
Урлаг, үзвэр,тоглоом наадам	5	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12	14
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн		0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2020 I-II	2021 I-II
	Тоо	
Бүгд	52	40
Менежер	1	1
Мэргэжилтэн	17	16
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	3	2
Контор, үйлчилгээний ажилтан	1	5
Худалдаа, үйлчилгээний ажилтан	11	5
ХАА, ой загас агнуурын ажилтан		0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	1	6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	6	5
Энгийн ажил мэргэжил	1	0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	11	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2020 II		2021 II	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	17	9	33	18
Менежер	0	0	1	1
Мэргэжилтэн	3	3	14	9
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	1	1	2	1
Контор, үйлчилгээний ажилтан	0	0	5	4
Худалдаа, үйлчилгээний ажилтан	8	4	3	3
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	0	0	3	0
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	3	0	5	0
Энгийн ажил мэргэжил	1	1	0	0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	0	0	0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2021 оны 02 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	тоо				
Бүгд	8	2	8	0	0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0				
Уул уурхай олборлолт	0				
Боловсруулах үйлдвэрлэл	0				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	0				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	0				
Барилга	0				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	0				
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	7	1	7		
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл	0				
Мэдээлэл холбоо	0				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл	0				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын	1	1	1		
Боловсрол	0				
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0				
Урлаг үзвэр тоглоом наадам	0				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2020 I-II	2021 I-II	2021 I-II 2020 I-II
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	7 009.7	7 846.6	111.9
Тэтгэврийн даатгалын сан	4430.9	5 271.2	119.0
Тэтгэмжийн даатгалын сан	499.5	555.1	111.1
Эрүүл мэндийн даатгалын сан	1151	1 310.8	113.9
ҮОМШӨ*-ний даатгалын сан	728	577.0	79.3
Ажилгүйдлийн даатгалын сан	200.3	132.5	66.2
Нийгмийн даатгалын сангийн зарлага	9 558.3	10 034.7	105.0
Тэтгэврийн даатгалын сан	6957.1	7 733.1	111.2
Тэтгэмжийн даатгалын сан	758.8	529.2	69.7
Эрүүл мэндийн даатгалын сан	1134.0	1 200.4	105.9
ҮОМШӨ*-ний даатгалын сан	421.0	401.2	95.3
Ажилгүйдлийн даатгалын сан	287.4	170.8	59.4

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	2020 I-II	2021 I-II	2021 I-II 2020 I-II
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	15626	15727	100.6
Албан журмаар даатгуулагчид	14920	14942	100.1
Аж ахуй нэгж, байгууллага	7461	7530	100.9
Төсөвт байгууллага	7459	7412	99.4
Сайн дураар даатгуулагчид	706	785	111.2
2. Тэтгэвэр авагчдын тоо	8906	9408	105.6
Өндөр насны тэтгэвэр	6466	6898	106.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1304	1386	106.3
Тэжээгчээ алдсаны	506	487	96.2
Цэргийн тэтгэвэр	472	490	103.8
ҮОМШӨ*-ний	158	147	93.0
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	7 376.2	7 878.2	106.8
Өндөр насны тэтгэвэр	5 144.5	5 819.7	113.1
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	852.6	898.3	105.4
Тэжээгчээ алдсаны	329.7	327.9	99.5
Цэргийн тэтгэвэр	628.4	683.8	108.8
ҮОМШӨ*-ний	421.0	148.5	35.3

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2020 II	2021 II	2021 II
	сая төгрөг		2020 II хувь
ДҮН	7009.7	7846.6	111.9
Айраг	120.1	107.8	89.8
Алтанширээ	50.1	54.1	108.0
Даланжаргалан	358.8	252.2	70.3
Дэлгэрэх	58.5	52.4	89.6
Иххэт	85.6	122.3	142.9
Мандах	62.2	58.6	94.2
Өргөн	152.8	108.9	71.3
Сайхандулаан	65.1	57.3	88.0
Улаанбадрах	60.6	41.4	68.3
Хатанбулаг	122.9	119.5	97.2
Хөвсгөл	53.6	54.3	101.3
Эрдэнэ	97.8	111.6	114.1
Сайншанд	3839.6	5023.2	130.8
Зүүнбаян баг	250.9	205.5	81.9
Замын-Үүд	1631.1	1477.5	90.6

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2020 II	2021 II	2021 II
	сая төгрөг		2020 II хувь
ДҮН	9558.3	10034.7	105.0
Айраг	453.6	474.7	104.7
Алтанширээ	171.8	187.0	108.8
Даланжаргалан	464.6	438.7	94.4
Дэлгэрэх	201.9	229.5	113.7
Иххэт	316.0	343.3	108.6
Мандах	201.8	213.9	106.0
Өргөн	317.3	302.0	95.2
Сайхандулаан	147.1	164.0	111.5
Улаанбадрах	202.6	225.8	111.5
Хатанбулаг	344.4	383.8	111.4
Хөвсгөл	175.5	182.6	104.0
Эрдэнэ	330.4	348.4	105.4
Сайншанд	4024.6	4449.8	110.6
Зүүнбаян баг	378.5	346.2	91.5
Замын-Үүд	1828.2	1745.0	95.4



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 02 сард

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-II 2020 I-II	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-II 2020 I-II
	2020 I-II	2021 I-II		2020 I-II	2021 I-II	
	тоо	тоо	хувь	сая төгрөг	сая төгрөг	хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	15920	9246	58.1	1779.5	1223.9	68.8
1. Халамжийн тэтгэвэр	1265	1298	102.6	455.2	752.6	165.3
Ахмад настны тэтгэвэр	87	102	117.2	30.1	58.8	195.6
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	357	357	100.0	124.8	204.4	163.8
Хөдөлмөрийн чадвараа 70%-с дээш алдсан ХБИ	443	467	105.4	158.2	268.9	169.9
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1	100.0	0.4	0.6	159.1
Өрх толгойлсон эх/эцэг/-ийн халамжийн тэтгэвэр	0	0		0.0	0.0	
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	377	371	98.4	141.7	220.0	155.2
2 Халамжийн тэтгэмж	946	1058	111.8	160.0	199.0	124.4
Эмнэлгийн хяналтад байдаг асаргааны тэтгэмж	0	0		0	0.0	
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	458	501	109.4	68.1	84.7	124.5
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	215	245	114.0	49.7	61.2	123.0
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	221	258	116.7	33.3	43.0	129.3
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	44	44	100.0	7.8	8.5	108.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	4	80.0	0.7	0.7	94.2
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	3	6	200.0	0.5	1.0	210.6
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-II	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-II
	2020 I-II	2021 I-II	2020 I-II	2020 I-II	2021 I-II	2020 I-II
	тоо		хувь	сая төгрөг		хувь
4. Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	228	295	129.4	75.0	146.1	194.8
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	217	248	114.3	74.3	143.2	192.8
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	11	47	427.3	0.7	2.9	400.0
5. Нийгмийн халамжийн сан	12	3	25.0	14.4	3.6	25.0
